



Иргэний Нисэхийн Ерөнхий газар

**Холбоо, навигаци, ажиглалтын дэд ажлын хэсгийн анхдугаар
хурал (MANPING-CNS SG/1)
(CRV АБ/1)**

Улаанбаатар, Монгол Улс, 2019 оны 6 дугаар сарын 21

Хэлэлцэх асуудал 2: Бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах виртуал бие даасан сүлжээ

БНХАУ-Япон-Монгол-ОХУ-ын хамтарсан хурлын тайлан

МОНГОЛ УЛС

(Бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан виртуал сүлжээний ажлын
баг)

ХУРААНГУЙ

Энэхүү мэдээллийн танилцуулга (IP)-аар БНХАУ-Япон-Монгол-ОХУ-ын хамтарсан бүсийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан виртуал сүлжээний зохицуулалтын хурлын тайланг танилцуулна.

1. ТАНИЛЦУУЛГА

- 1.1 2019 оны 5-р сарын 6-7-ны өдрүүдэд ICAO APAC Regional Office-т Хятад, Япон, Монгол, ОХУ-уудын хамтарсан Зохицуулах уулзалт зохион байгуулсан. Уулзалтын гол зорилго нь CRV OG/5 хурлаас гарсан зөвлөмжийг дагаж мөрдөж, APAC бүс нутаг болон ОХУ улсуудын хоорондын IWXXM мэдээлэл дамжуулах харилцаа холбоо, нисэхийн суурин холбооны шаардлагыг судлах явдал юм. Уулзалтаар нисэхийн суурин холбооны үйлчилгээг сайжруулахад нэгдэн орох зэрэг практик ажиллагааны шийдлийг боловсруулна. ОХУ болон Ази/Номхон далайн бүсийн улсууд хооронд CRV сүлжээ ашиглан IWXXM форматаар цаг уурын мэдээ солилцох боломжийг бүрдүүлнэ. Тус хуралд 4 улсаас 18 төлөөлөгч оролцсон.
- 1.2 ICAO-ийн Хавсралт 3-т оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 2020 оны 11-р сарын 5-аас IWXXM форматаар цаг уурын мэдээллүүдийг түгээхийг шаардсан. [ТАК эсвэл энгийн хэллэгээр мэдээлэл түгээхээс гадна]. Үүнд:
 - a) 2016-2018: TAC нь Стандарт, IWXXM нь METAR / SPECI / Trend, TAF, VAA, TCA, SIGMET, AIRMET-д зөвлөмжийн дагуу туршилтаар;
 - b) 2018: TAC нь стандарт, IWXXM нь METAR / SPECI / Trend, TAF, VAA, TCA, SIGMET, AIRMET, Space Weather зөвлөмжийн дагуу туршилтаар;
 - c) 2020: TAC стандарт, IWXXM нь METА-ийн стандарт;

2. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ОХУ болон Ази/Номхон далайн бүсийн улсууд хооронд харилцан холболтыг үүсгэх арга хэмжээ авч ажиллах талаар гаргасан дүгнэлтүүд

- 2.1 2020 оны 11-р сараас эхлэн IWXXM форматаар цаг уурын мэдээлэл солилцох шаардлагыг хангахын тулд IP-д суурилсан AMHS холболтыг зохион байгуулах шаардлагатай бөгөөд (БНХАУ, Япон, Монгол) болон АНУ-ууд ОХУ-ыг Москва, Хабаровск, Иркутск гэсэн 3 НХУТ-өөс Бээжин, Фукуока болон Улаанбаатартай CRV сүлжээ ашиглан ОХУ ба APAC-ийн хоорондох харилцан холболтыг тогтооно. Тиймээс ОУИНБ-ын APAC Бүсийн эдгээр 3 байршилд CRV-д орох зорилтот хугацааг тодорхойлохын тулд ОХУ-ыг RCCW Глобалтай хэлэлцээр хийхийг хүссэн. Мөн Хятад, Япон, Монгол улсууд ОХУ-ыг 2019 оны эцэс гэхэд CRV сүлжээнд холбогдохыг хүссэн.
- 2.2 2020 оны эхний хагаст болох уулзалтаар дээрх гарцуудын хооронд AMHS-ийг турших зорилтот хугацааг тогтооно.
- 2.3 Хоёр талын харилцан гэрээний дагуу хугацааг тогтоох хийгдэх бөгөөд нь холбогдох улсуудын хооронд гарын үсэг зурж баталгаажуулна.

3. Хурлын үр дүн:

- 3.1 Оролцогчдоос:
 - a) Шийдвэрийн төсөл танилцуулах, хэлэлцүүлэх;
 - b) Холбогдох бусад асуудлууд

— ТӨГСӨВ —